

ХЯТАД-МОНГОЛ ОРЧУУЛГАД ӨВӨР МОНГОЛ ОРЧУУЛАГЧИД ТАВИГДАХ ҮНДСЭН ШААРДЛАГЫН ТУХАЙ

Б.Хөгжилт¹⁸⁸

Орчуулага гэдэг бол өргөн утгаараа хэл ба хэлний, хэлний хувилбар ба хэлний хувилбарын, хэл ба хэлний бус кодын хоорондох хөрвүүлэлт, үндсэн мэдээллийн дамжуулалтыг хэлнэ. Явцуу утгаараа хэлний хоорондох хөрвүүлэлт болно. Иймээс орчуулага нь орчуулагчаар субъект болгосон хэлний хоорондох, хэл болон хэлний бус код хоорондох мэдээллийг итгэмжтэй, чөлөөтэй, яруу тод дамжуулах үйл явц мөн. Хятад, Монголын харилцаа бүх салбарт өргөн хөгжиж байгаа өнөө үед харилцааны гүүр болох орчуулагчдад тавигдах шаардлага улам бүр өндөржсөөр байна. Өвөр Монголчууд бол Монголчуудтай нэг үндэстэн, Хятадын цөөнх болсны хувьд, хэлний талаар өөрийн давуу талтай ч түүхийн зарим цаг үед хоёр орны харилцаа зогсонги байсан, ондоо ондоо улс төр, соёлын нөлөөлөл гэх мэт шалтгаанаас улбаалж, зарим нэр томъёо, хэл хэллэгийн ялгаа бий болж өргөжсөн нь ч үгүйсгэхийн аргагүй юм. Ийнхүү Өвөр Монгол орчуулагчид тавигдах шаардлагад нийтлэг зүйлс байхаас гадна, өвөрмөц зүйлс бас байгаа юм. Эдгээрээс шинжлэн өгүүлбээс:

1. Бат бэх хэлний үндсэн чадавхтай байх хэрэгтэй

Орчуулагч нь анхны хэл ба зорилтот хэлийг эзэмшиж, эхийг зөв ашиглах, ойлгох, орчуулах чадвартай байх ёстой. Өөрөөр хэлбэл, Монгол, Хятад хэлний орчуулагад орчуулагч нь хоёр хэлний зүй, өгүүлбэр, эхийн бүтцийг сайн эзэмшсэн мөртлөө үгсийн сангийн баялагтай байх хэрэгтэй. Өвөр Монгол орчуулагчдын хувьд, бас кирилл монгол үсгийн хэлзүй, өгүүлбэр, эхийн бүтцэд нилээд суралцсан байх шаардлагатай.

Мэргэжлийн хувьд, заавал хэлний мэргэжил сурсан гэж хязгаарласан ёс байхгүй, учир нь орчуулагын цар хүрээ маш өргөн, адил бус хэлбэр төрөл, цаг орон зайд адил бус мэргэжлийн, төвшиний орчуулагчийг шаарддаг. Мэдээж мэргэжлийн орчуулагчид илүү давуу талтай байдаг.

2. Соёлын суурь мэдлэгээр баян байх хэрэгтэй

Энэ нь анхны хэлийг зөв ойлгох, эх бүтээлийн үзэл санаа, агуулгыг ойлгомжтой, итгэмжтэй, яруу тод дамжуулан илэрхийлэхийн бас нэгэн үндсэн нөхцөл болно.

¹⁸⁸ ӨМИС-ийн Монгол судлалын төвийн дэд профессор, Монгол судлалын дээд сургуулийн Кирилл монгол мэргэжилийн бакалаврын ангид “монгол-хятад орчуулгын онол ба практик” хичээл заадаг.

Соёлын суурь мэдлэгт хос хэлний түүх, шашин, улс төр, газар зүй, цэрэг, дипломат, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан технологи, ёс заншил гэх мэтийг хамаарна. Тэгвэл Өвөр Монгол орчуулагчид дээрх шаардлага байхаас гадна, бас хоёр орны монгол үг үсгийн ялгааг эрхбиш сайн ойлгосон нь алдаа мадаг гарахаас сэргийлнэ.

◆ Хэл нь нийгмийн хөгжил, өөрчлөлтийн дагуу, түүхийн өөр өөр цаг хугацаа, орон зайд адил нэг үг нь өөр өөр утгатай байх хандлагатай байдаг. Үүнийг тухайн утга санаагаар ойлгон дамжуулсан нь чухал. Жишээлбэл:

-Орныг Монголд улс орон (国家) гэх утгаар хэрэглэж байхад, Өвөр Монголд орон нутаг (地方, газар орон (地点), бүс нутаг гэсэн өргөн утгаар (地区) ойлгож байдаг.

-Монголд ач (孙子) гэхэд Өвөр Монголд омболо гэж, ач нь авгын хүүхдүүдээр ойлгогдоно (侄子).

-Гэх мэтчлэн Амаржих газрыг (妇产科) Хөнгөжөх газар гэж, Террорист үйл явдал, алан хядах ажиллагааг (恐怖事件) Сүрдүүлгийн хэрэг явдал гэх зэрэг маш олныг дурдаж болно.

◆ Зарим үг нь тодорхай нөхцөл байдалд бий болдог. Жишээлбэл:

-Монголд Нинжа гэдэг нь алтны шороон ордыг ганц хоёул байгаль орчинд халтай аргаар олборлож байгаа хүмүүсийг хэлнэ. Энэ нь япон хэлний 忍者 гэсэн үгээс гаралтай билээ.

-Канондох нь хувилах гэсэн утгатай байж, Японы Canon (佳能) гэсэн брэндээс гаралтай нь тодорхой.

◆ Хэвшсэн үг өгүүлбэрүүдийн ялгаа.

-Тоглоом яриаг Өвөр Монголд наадам хийлээ гэх (开了玩笑).

-Хүндэтгэлийн арга хэмжээг зочлох гэх (设宴款待).

-Тавтай саатна уу-г баярлан угтъя гэх (欢迎).

-Хийлгэсэн хагалгааныхаа дагуу хяналтанд орж байх ёстой хяналтанд орохыг байцаалгах гэх (根据手术情况必须做复查).

◆ Газарзүйн нэр томъёоны ялгаа.

-Температурыг агаарын дулаан гэх (气温).

-Хэмийг градус гэх (度数).

-Цаг агаарыг цаг уур гэж (天气), харин цаг уур нь Монголд метеорологийг заана (气象).

- Геоморфологиг газрын гадар хөрс гэх (地貌) .
- Үлэг гүрвэлийг аварга гүрвэл гэх (恐龙) .
- ◆ Нийгэм улс төрийн түүхэн замнал адил бусаас нилээд их нэр томъёоны ялгаа бий болсон байна.
 - Үйлдвэрчний эвлэлийг ажилчны эвлэл гэх (工会) .
 - Иргэнийг эрхэт ард гэх (公民) .
 - ААН-г аж ахуйлал гэх (企业) .
 - Группыг бүлэглэл гэх (集团) .
 - Элит, Шилмэлийг охь содууд гэх (精英) .
 - “Монголыг танилцуулах” аяны хүрээг аяны хөдөлгөөн гэх (在推介蒙古活动范围内) .
 - Үнэт зүйлсийг өртгийн үзэл буюу эд баялаг гэх (价值观或者财富) .
 - Эдийн засагийг аж ахуй гэж (经济) , харин эдийн засаг нь Өвөр Монголд санхүүг (财政) заана.
 - Банк санхүүг мөнгөн гүйлгээ гэж (金融) , харин мөнгөн гүйлгээ нь Монголд 货币流通 гэсэн утгатай.
 - Хотын дүүргийг хотын тойрог гэж (城区) , харин дүүрэг нь хот ойролцоох тосгоныг заана.
 - Хороололыг орон сууцны тойрог гэх (住宅小区) .
 - Валютыг гадаад гуйвуулга гэх (外汇) .
 - Ашигт малтмалын ордыг хүдрийн хэвтэр гэх (矿床) .
 - Семинар, эрдэм шинжилгээний бага хуралыг судлан ярилцах хурал гэх (研讨会) .
 - Ашигт малтмалын нөөцийн нөөцийг хадгалагдац гэх (储量) .
 - Баялагыг эх баялаг гэх (资源) .
 - Алба, тамгын газрыг албан гэр, албан газар, албан танхим гэх (办公室、办公处、办公厅) .
 - Стратегийг байлдах бодлого гэх (战略) .

-Геополитикийг газарзүйн улс төр гэх (地缘政治) .

-Үүрэг рольг үйлдэл гэх (作用) .

3. Орчуулгын онол, нийтлэг ур чадвард танил дасал байх хэрэгтэй

Гадаад, дотоодын алдарт орчуулагчдын дүгнэсэн орчуулгын тухай үндсэн стандартад уг зохиолд үнэнч, үг хэлээр чөлөөтэй бөгөөд яруу тод зэргийг чухалчилсан байдаг. Үнэнч итгэмжтэй байдал бол орчуулгын амин чухал асуудал болно. Анхны хэлний жинхэнэ утгад заавал үнэнчээр хандсан байх хэрэгтэй. Хэлээр чөлөөтэй гэдэг нь анхны хэлний бүтцэд хүлэгдэхгүй, харин зорилтод хэлний өвөрмөц хэллэгийн дагуу орчуулан зохицуулсан байх. Үүнд үсэгчилж орчуулах болон утгачилж орчуулах гэсэн асуудал бий. Хоёуланг нь заавал уян хатан уялдуулсан байх хэрэгтэй. Аль нэгийг давуулж, өрөөл нэгийг дордуулж болохгүй. Хятадын алдарт уран зориолч Ба Жинь (巴金) ярихдаа: “миний бодлоор, үсэгчилэх болон утгачилах гэсэн ялгаа баймааргүй, орчуулгын арга ижилхэн зүйл бий, сайн орчуулага нь үсэгчилсэн мөртлөө утгачилсан байж таарна” гэжээ. Жишээлбэл:

-Ямааны махыг халуунд нь гэснийг үсэгчилбэл: 山羊肉须趁热吃, утгачилбал:趁热打铁.

-Хурын дараах мөөг шиг гэснийг үсэгчилбэл: 雨后蘑菇般, утгачилбал: 雨后春笋般.

-Нэг сумаар хоёр туулай буудах гэснийг үсэгчилбэл: 一箭双兔, утгачилбал: 一箭双雕、一举两得、一石二鸟.

-远亲不如近邻-г үсэгчилбэл: Холын хамаатан ойрын хөршийг хүрэхгүй, утгачилбал: айл хүний амь нэг, саахалт хүний санаа нэг.

-读万卷书, 行万里路-г үсэгчилбэл: Түмэн боть ном уншиж, түмэн газар явнам, утгачилбал: эрдэнээр биеэ чимэхээр эрдмээр биеэ чим, эсвэл, олбогийг цоортол суусан мэргэнээс олныг тойрсон мунхаг дээр.

-掩耳盗铃-г үсэгчилбэл: Чихээ бүглэж хонх хулгайлах, утгачилбал: өөрийгөө хуурах.

-说一口流利的汉语-г үсэгчилбэл: Хятад хэлээр урсам ярьдаг, утгачилбал: хятад хэлээр чөлөөтэй “ус цас шиг”ярьдаг.

Яруу тод гэдэг нь оновчтой, яруу, авсархан, үгийн баяныг дэндүү хэтрүүлэхгүйг хэлнэ. Энэ талаар “орчуулага бол урвалт мөн”, “Орчуулга бол

бүсгүй хүн шиг , итгэлтэй нь гоё биш, гоё нь итгэлтэй биш” гэж анхааруулж хэлсэн сургаал үгнүүд бий.

Онолын талаар, АНУ-ын Найдагийн /Eugene Nida/ “Уншигчийн хариу тусгалын онолд” уг зохиолд үнэнч, хэлбэр нь зохистой, уншигчийн сонирхолыг татах бөгөөд өгөх мэдрэмж нь нэгэн адил гэж, Хуучин ЗХУ-ын Федоровын “дүйцсэн онолд” үүрэг роль ба хэл текст нь дүйцсэн байх гэж, Хятадын Чень Жуншүгийн (钱钟书) “идээшүүлэх сургаалд” хэлний зуршлын ялгаанаас шалтгаалж, албадан мохоосон ул мөр үлдээхгүй мөтлөө анхны амтыг бүрэн хадгалсан” гэж тодорхойлсон байдаг.

4. Толь бичиг болон туслах арга хэрэгсэлд танил дасал байх хэрэгтэй.

Орчуулагчийн санах ой, мэдлэг нь хязгаарлагдмал байдаг учраас асуудал тулгархаар хаана зөв хариулт олж авахыг мэдсэн байх ёстой. Толь бичгээс гадна туслах хэрэгсэлд эдүгээ нийтлэг хэрэглэгдэж байгаа google орчуулага гэх мэтийг сайн ашиглаж сурсан байх хэрэгтэй. Гэхдээ тэдгээр нь зөвхөн туслах хэрэгсэл төдий, нэр томъёо хайхад дөхөм ч өгүүлбэр зүйлсийн орчуулагад учир дутагдалтай. Хятадын хэлний шинжээч Лю Шүшиангийн (吕叔湘) хэлсэнчлэн: “Анхны гар бичмэлийн хажууд толь бичиг, хэлний зүйн ном тавьж, ийш тийшээ харж байж сая нэг мөр орчуулсан бол энэ тухай ярихаа больёо. Ландерс /Landers/: “Хүчин чармайлт хийхгүй, бухимдалыг тэвчих хүсэлгүй хүн хэзээ ч орчуулагч болж чадахгүй” гэжээ.

5. Аман орчуулагч нь сайн хэлэлцээрч байх хэрэгтэй.

Сайн хэлэлцээрч гэдэг нь өөрийн гүүр буухиагийн үүрэг ролио бүрэн гүйцэд биелүүлсэнийг хэлнэ. Орчуулагч нь яригч ба сонсогчын хооронд яасан ч гуравдагч тал болж болохгүй. Гоголийн /Gogol/ хэлсэнчлэн: “Төгс Орчуулагч нь шил шиг байх ёстой, ил тод бөгөөд сонсогч, уншигч түүний оршихуйг мэдрэхгүй” гэжээ.

Ашигласан ном зүй:

1. 奈达、泰博，翻译理论与实践，1969年；
2. 刘季春编著，实用翻译教程（修订版），中山大学出版社，2007年；
3. Б.Хөгжилт. Монгол (кирилл) хятад орчуулгын суурь хичээлийн хөтөлбөр,2014